



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/176

Зуунмод

Сумдад тэжээлийн буудай,
овьёос хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас олгосон тэжээлийн буудай, овьёос болон түүний тээвэрлэх шатахууныг сумдад олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилагдсан тэжээлийн буудай, овьёосыг шуурхай татан авч, малчдадаа хүргэх ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт, ажлыг шуурхай зохион байгуулж, удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга)-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4124010440

doc: Zahiramj 2024.1uliral

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 19 -ны өдрийн А/176 дүгээр
захирамжийн хавсралт



СУМДАД ОЛГОХ БУУДАЙ, ОВЬЁОСНЫ ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Будаа /тн/	Овьёос /тн/	Шатахууны дэмжлэг /талон/
1	Алтанбулаг	35	5	700,000
2	Аргалант	20	5	700,000
3	Архуст	13	2	800,000
4	Батсүмбэр	10	3	400,000
5	Баян	15	3	800,000
6	Баяндэлгэр	15	3	800,000
7	Баянжаргалан	20	5	1,000,000
8	Баян-Өнжүүл	25	5	1,000,000
9	Баянхангай	20	5	700,000
10	Баянцагаан	25	5	1,000,000
11	Баянцогт	12	3	500,000
12	Баянчандмань	12	3	300,000
13	Борнуур	13	2	300,000
14	Бүрэн	35	5	1,000,000
15	Дэлгэрхаан	10	2	1,000,000
16	Жаргалант	10	3	300,000
17	Заамар	20	5	1,000,000
18	Лүн	30	5	900,000
19	Мөнгөнморьт	12	3	1,000,000
20	Өндөрширээт	35	5	700,000
21	Сүмбэр	12	3	300,000
22	Сэргэлэн	12	3	700,000
23	Угтаалцайдам	10	2	500,000
24	Цээл	10	2	500,000
25	Эрдэнэ	12	3	800,000
26	Эрдэнэсант	30	5	1,000,000
27	Зуунмод	17	3	700,000
28	Аймгийн нөөц	-	2	-
	Нийт	490	100	19,400,000

___оОо___